



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/201

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төсвөөр санхүүжигдэх ГААОНӨГ/202304028 дугаартай Шүүхийн Тамгын газарт автомашин нийлүүлэх ажлыг гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Шүүхийн Тамгын газар (Ж.Ганболд)-т олгосугай.

2.Ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх, үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг аймгийн Шүүхийн Тамгын газар (Ж.Ганболд)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР